

НИЙГМИЙН ШУДАРГА ЁСНЫ ТУХАЙ ОНОЛ, ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Түлхүүр үг: шударга ёс, ардчилал, урвуу ардчилал, эрх баригч цөөнхийн засаг, улс төр, бизнесийн элит бүлэг, нийгмийн тэгш биш байдал, ядуус, нийгмийн бодлого

Товчлол: Монгол улс ардчилалд шилжих явцад улс төрийн эрх мэдэл болон эд баялагийн шинэ хуваарилалт хэр зэрэг шударга явагдаж байгааг авч үзнэ.

Бяцхан оршил

Монгол улс нийгмийн зохион байгуулалтын тухай өрнөдийн онол төсөөллөөр бараг бүхэл зуун жил амьдарч байна. 1921 онд мандсан Монголын ардын хувьсгал Монгол улс Өрнөд Европод үүссэн хувьсгалч маркст суртлыг хүлээн авч ЗХУ-ын ивээл дор орсныг зарлан тунхагласан бөгөөд капиталист бус хөгжил, социализмын замаар замнахдаа олсон ололт амжилт, алдсан алдаа дутагдлуудаа ил тод хэлэлцээд өнгөрсөн билээ.

1990 оноос манай орон өрнөдийн маркст онол сургаалаа мөнхүү өрнөдийн либерализм хэмээх эрх чөлөөний суртлаар халж хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгож байна. Нэг үгээр хэлбэл нийгмийн байгуулал буюу нийгмийн зохион байгуулалт ямар байвал шударга байх вэ? гэдэг асуултад Дорно дахины соёлд хамаарах Монгол орон Өрнөдийн үлгэр загварыг сонгоод бараг нэг зууныг элээж байна. Энэ хугацаанд шударга нийгмийн тухай маркст онол төсөөлөл маань цагийн аясыг даалгүй халагдаж цагийн сорилтыг даасан либераль ардчилсан капитализмын загварыг авахаас өөр аргагүй болсон билээ.

Миний үеийнхэн шударга ёсны тухай маркст сургаалыг Маркс, Энгельс, Лениний зохиолуудаас уншиж мэдэх бололцоотой байсан төдийгүй энэ сургаалын амьд биелэл болсон социалист нийгэмд төрж өсч, сурч боловсорч, амьдарч ажиллаж байсан маань шударга ёсны тухай олж авсан хуучин төсөөллөө одоогийн шинэ цаг үеийнхтэй амьдралын туршлагынхаа үүднээс харьцуулах, харгалзуулах бололцоо олгож байна. Шударга ёсны тухай маркст төсөөллөөс өөр онолын төрлийн талын ойлгоцгүй бидэнд өрнөдийн философи, улс төр судлал, эрх зүй, ёс зүйн салбарт боловсруулсан олон онол, сургаалыг үзэж танилцах, сурч мэдэх нь бараг энэ нас гүйцэхгүй бэрх ажил юм. Манай орон ардчилал, зах зээлд шилжих явцад улс төр, эдийн засаг болон нийгмийн амьдралыг бүхэлд нь хамарсан их өөрчлөлтийн явцад гарч байгаа сайн болоод саар үр дагаврууд аяндаа нийгмийн шударга ёсны тухай практик, ажиглалтын түвшин, хэмжээний яриа хөөрөөг өдүүлж байна.

Нийгмийн шударга зохион байгуулалт байдаг уу?

Социалист нийгэм, марксч-ленинч үзэл суртлын ноёрхлын үед нийгмийн шударга ёсыг юуны өмнө үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмших нийгмийн өмчийн харилцаанаас ургуулан тайлбарлаж ирсэн. Социалист нийгэмд дарлагч ба дарлуулагч анги байхгүй болж, ажилчин анги-хоршоолсон тариачин-хөдөлмөрийн сэхээтэн гэсэн нөхөрсөг анги давхраа бүхий эв санааны нэгдэл бүхий нийгэм цогцлон бүрэлдсэнээр хөрөнгөтний нийгэмд байсан нийгмийн дарлал мөлжлөг, хөрөнгөтний улс төр, эдийн засгийн ноёрхол мэт шударга бус байдлыг арилгаж түүхэнд анх удаа шударга ёсыг тогтоосон нийгэм байгуулсан гэж номолдог байлаа. Ангиудыг устгаж, ангигүй коммунист нийгэмд хүрсэн цагт л бүрэн тэгш байдал, шударга ёсны талаар ярьж болно гэдэг байв. Шударга ёсны тухай марксч-ленинч сургаал үл гүйцэлдэх мөрөөдөл байсан учраас амьдралд бүрэн хэрэгжээгүй бөгөөд хэрэгжих бололцоогүй байсныг социалист туршилтын замнал харуулсан бөлгөө.

Коммунистууд хөрөнгөтний нийгмийн зохион байгуулалтыг шударга бус гэж үзэж тэмцэж байсантай адил 1980-аад оны сүүлчээр социалист байсан орнуудын нам төрийн удирдлагаасаа эхлээд энгийн иргэдээ хүртэл амьдарч байгаа нийгмийнхээ тоталитар зохион байгуулалтад байгаа үй олон согогийг ил тод ярьж эхэлснээр ардчилсан засаглал, зах зээлийн эдийн засаг, улс төр, үзэл суртлын олон ургалч үзлийг зөвшөөрдөг, хүний эрхийг дээдэлдэг нийгэм-улс төрийн зохион байгуулалтыг илүү шударга, зөв юм гэж үзэх болсон билээ. Энэ бол Өрнөдийн ардчилсан нийгмийн үлгэр загвар юм. Ингээд 1989 оны сүүлчээр Европын социалист орнуудад, 1990 онд Монголд, 1991 онд ЗХУ-д тоталитаризмын эсрэг чиглэсэн ардчилсан хувьсгалууд мандаж дэлхийн социалист систем нуран унасан билээ.

Өдгөө социалист байсан орнууд нийгмийн тоталитар зохион байгуулалтаас ардчилсан зохион байгуулалтад шилжих шилжилтийн хүнд үеийг үндсэндээ туулаад байна. Ардчилалд шилжихлээр хүмүүсийн амьдрал дээшилж, бүх юм сайн сайхан болох мэтээр төсөөлж байсан нийгмийн болон хувь хүний горьдлого, хүлээлт хэр зэрэг биелж байна вэ? гэж асуух төдийгүй хариулах боломжтой болоод байна. Энэ тухайд бид Монгол орноороо жишээлэн ярья.

Монгол дахь урвуу ардчилал

Ардчилал нэртэй нэг хүний засаг ч байдаг. В.И.Ленин хөрөнгөтний ардчилал бол хуурмаг, нэр төдий, ёс төдий, язгууртан цөөнхийн ардчилал байдаг хэмээн хурц шүүмжилдэг байсан. Даанч социализмын үед ч ЗСБНХУ болон социалист бусад оронд социалист ардчилал нэртэй нэг хүний болон нэг намын хэмжээгүй эрхт тоталитар дэглэм ноёрхож байсан билээ. Дэлхийн социалист систем нурж ЗХУ задарсны дараагаар ч Дундад Азийн тусгаар тогтносон улсуудад, тухайлбал Туркменистанд С.Ниязов, Тажикстанд И.Рахмонов, Узбекстанд И.Каримов, Казакстанд Н.Назарбаев, Азербейжанд эцэг, хүү Алиевийн зэрэг ардчилал нэртэй нэг хүний юмуу, нэг гэр бүлийн халаагүй засаг оршиж байна. Ийм засгийн эсрэг сөрөг хүчний тэмцэл Гүрж, Украин, Киргизстанд ялаад байна. Тэгэхдээ дээр дурдсан бүх оронд "шар" ч юмуу ямар нэг өнгөтэй хувьсгал заавал гарна гэсэн үг бишээ. Учир нь засаглалын хэлбэр ямар байхаас улс орны хөгжил, ард түмний амьдрал ямар байх нь шууд хамаардаггүй. Ерөнхийлөгч Ниязовын тогтоосон нэг хүнийг тахин шүтэх тоталитар дэглэмийн улмаас газрын тос, шатдаг хийгээр баян Туркменистан улсын ард түмнийх нь амьдрал дорой байхад Ниязовт зориулан Ким Ир Сенийх шиг том хөшөө босгожээ. Тэгвэл ОХУ-ын Татарстанд сүүлийн найман жилийн хугацаанд 40000 айлыг орон сууцаар үнэ төлбөргүй хангасан гэж ерөнхийлөгч М.Шаймиев РТР-д саяхан өгсөн ярилцлагадаа хэллээ. Засгийн бүх эрх мэдэл нэг хүний гарт төвлөрсөн ийм орнуудад эдийн засаг нь хөгжиж ард түмнийх нь аж амьдрал дээшилж байгаа ч гэсэн ардчилал нэр төдий, ёс төдий, хэлбэрийн, хуурмаг болдогоор барахгүй бүүр нэг хүний тоталитар дарагуйллын дэглэмийн халхавч болдог байна. Дээрх орнуудтай харьцуулахад Монгол улс бол яриагүй ардчилсан орон болсонд эргэлзэх зүйл алга. Сөрөг хүчний болон зарим нийтлэлч, сэтгүүлчдийн зүгээс МАХН засгийн эрхийг дангаар барьсан 2000-2004 онд манай орон ардчиллаас ухарч тоталитаризм руугаа эргэж орж байна гэх зэмлэл, шүүмжлэл бол үзэл суртлын тэмцлээс үүдэлтэй нэлээн өрөөсгөл, хэтрүүлэгтэй, сүржигнэсэн мэдэгдэл байсан. Тэглээ ч гэсэн манай ардчилалд шүүн хэлэлцэж, засч залруулахгүй бол ардчиллыг маань урвуулах ноцтой хандлага байгааг энд үгүүлэх болно.

Ардчиллыг урвуулахуй. Монгол улс бол ардчилсан Үндсэн хуультай, төрөө бүх нийтийн ардчилсан сонгуулиар эмхлэн байгуулдаг учраас

ардчилсан улс мөн гэж үзэх нь зүйн хэрэг. Бид ардчиллын дүрэм журам, хэм хэмжээнүүдийг Үндсэн хууль болон бусад хуулиуддаа муугүй бичсэн гээ. Ардчилал гэдэг бол ард түмний, нийт иргэдийн хамгийн том зөвшилцөл, гэрээ юм гэж үзвэл гэрээнд оролцогч талууд үүргээ яв цав биелүүлэх ёстой. Хэрэв оролцогч талууд бусдыг хохироосон ч хамаагүй хувь хувийн сонирхлоо гүйцэлдүүлэхээр хичээж, эсвэл хуулийг өөр өөрсдийнхөө сонирхолд нийцүүлэн гуйвуулж, гажуудуулж эхлэвэл ямар ч гэрээ хэлцэл, тохиролцоо хэрэгжих боломжгүй болно. Хувь хүнээс эхлээд төрийн дээд байгууллага хүртэл хууль зөрчиж завхруулдаг явдал бол ардчиллыг урвуулж байгаа хэрэг мөн. Социализмаас ардчилалд шилжиж байгаа зарим нэг орон, тэр дотроо манай оронд чухам ийм байдал их байгаа учраас нийгэмд эмх замбараагүй, дэг журамгүй, захиргаагүй явдал газар авч бүхэлдээ ардчилсан өөрчлөлтийн үйл явцад, тэр дотроо ардчиллыг хэвшүүлэн тогтооход их хүндрэл бэрхшээл учруулж байна.

Хэн ардчиллыг урвуулж байна. Ардчилал бол ард түмний засаг гэж ярьдаг ч ард түмэн бүх нийтээр төрийн хэрэгт оролцож чаддаггүй, тэгэх ч бололцоо байдаггүй. Нөгөө талаас ард түмний сонгож байгуулсан төр нь тэдний хүсэл зоригийг үргэлж, аяндаа илэрхийлж байдаггүй. Төрийн эрх мэдлийг гартаа оруулсан нам, эвсэлд бас өөрийн бүлгийн сонирхол байдаг. Тэд түүнийгээ гүйцэлдүүлэхэд эрх мэдлээ урвуулан ашиглах бололцоотой төдийгүй ингэж ашигласаар ирснийг манай улс төрийн амьдрал ч бас харуулж байна. Ийнхүү ард түмний засаг маань аль нэг намын дээд хэсэг, тэднийг тойрон хүрээлэгчдийн засаг болж хувирах бололцоотой төдийгүй ерөөсөө ядуу буурай оронд ардчилал эрх баригч цөөнхийн засаглал болж хувирах хандлагатай байдаг. Манай оронд ч энэ хандлага нэг намын засаглалын үед илэрсээр ирлээ.

Улс төр бизнесийн элит бүлэг. Ядуу оронд эрх дархтай болсон хүмүүс юуны өмнө өөрсдийнхөө хувийн явцуу сонирголоо гүйцэлдүүлэхэд төрийн өндөр албан тушаалаа урвуулан ашиглаж эхэлдэг нь нэгэнт илэрхий болсон зүйл бөгөөд Монгол улс ч энэ жишгээс хазайсангүй. Манай төр засгийг эмхлэн байгуулахад хөрөнгө мөнгөтэй, баян чинээлэг хүмүүс оролцдог жишиг аяндаа бүрэлдэн тогтсон билээ. Намуудын доторхи хөрөнгө мөнгөтэй бизнес бүлэг болон төрийн өндөр албан тушаал хашиж нэр төр олсон, төрийн албаар дамжин хөрөнгөжсөн бүлэглэлүүд нэр нөлөө, эрх дархаа бэхжүүлсээр байгааг манай улс төрийн амьдрал харуулж байна. УИХ-ын

сонгуульд нэр дэвшигчдийн шалгуур нь тэдний мэдлэг боловсрол, нэр хүнд биш мөнгө болсон байна. Монголын парламент "Мөнгөний" парламент болж нэг ёсны хаалттай тогтолцоо бүрэлдэж байна. Нэг үгээр хэлбэл Монголд "засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байдаг" биш, улс төр, бизнесийн явцуу бүлэглэлийн гарт байдаг орон болж магадгүй байна. Энэ бүлэглэл өөрсдийгөө элитүүд гэж ил далд нэрлэцгээх цаг ирэх нь. Ийм бүлэглэлүүд ардчиллаар халхавчлан засгийн эрхийг ээлжлэн барьж өөрсдийн хувийн бэртэгчин сонирголоо хэрэгжүүлээд байх бололцоотой байдгийг аль 1956 онд АНУ-ын социологич Р.Миллс "Эрх баригч элит" гэдэг зохиолдоо нотолсон билээ.

ОХУ-д гэмт хэргийн ертөнц, мафиуд улс төрд их нөлөөтэй байгаа тухай яригддаг. Манай оронд ч гэсэн шинэ хөрөнгөтнүүд социализмын үеийн ард түмний, нийгмийн гэх өмчийг хувьчлах, худалдаж авах нэрийн дор хулгайлж, луйвардаж, завшиж өндийсөн учраас төр засгийн болон бизнесийн хүрээнийхний дотор сэжигтэй хүмүүс цөөнгүй байдаг билээ. Монгол улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн кампанийн үеэр нэр дэвшигч, гол хоёр өрсөлдөгч Н.Энхбаяр, М.Энхсайхан хоёрын бүтээсэн буян, үйлдсэн нүглийг сар илүү дэнсэллээ. Буянаасаа илүү нүгэлтэй хүмүүс юм шиг сэтгэгдэлтэй үлдлээ. Монголын толгой улстөрчид ийм байхад Монголд ямар ардчилал, ямар шударга ёсны тухай ярих вэ?

Төрийн албан хаагчид хэн бэ? Манай оронд ардчилал иргэд сонгуульд санал өгсөнөөр дуусдаг буюу дөрвөн жил завсарладаг. Өөрөөр хэлбэл энэ хугацаанд сонгогдсон төр засаг нь сонгогч түмний зүгээс тавих хяналтгүй, хяналтгүй учраас хариуцлагагүй байж болдог нь нөгөө урвуу тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг нь юм. Хариуцлага хүлээдэггүй бөгөөд хээл хахууль авч баяжин хөлжиж болдог учраас төр засгийн бүх шатны байгууллагуудад ажиллах нь манайд хамгийн ашигтай бизнес болон хувирчээ. Тийм учраас мөнгө хөрөнгөтэй хүмүүс төрийн сонгуульд болон томилгооны албан тушаал руу хошуурч байна. Тодорхой албан тушаал хүртэхийн тулд намдаа хандив өгч санхүүжүүлэх явдал бичигдээгүй хууль болжээ. Түүгээр ч үл барам тодорхой албан тушаал бүрт тогтсон ханш байдаг тухай ярьдаг болжээ. Төр засгийн байгууллагуудын ажил яаж явдаг тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр гардаг мэдээлэл, шүүмжлэл болон хүмүүсийн халагласан яриаг сонсоход иргэдээс авсан татварын мөнгөөр санхүүжээд зогсохгүй дээрээс нь

хээл хахууль авч баяжиж хөлждөг төрийн байгууллага, албан хаагчид бий болоод удаж байна. Тэд л авлига, хээл хахуулийн торон сүлжээ бүтээжээ. Гадаадаас ирж байгаа хандив, тусламж, зээл, төслийн хөрөнгийг замаас нь хумслаж хуваасаар дуусгадаг бузар бизнес цэцэглэх болсон. Энэ мэтчилэн авлигач, хахуульчдын "ажилладаг" объект газар сайгүй байдаг байна.

1996, 2000 оны УИХ-ын сонгуулийн дараа засгийн эрх авсан намууд улс төрийн болон захиргааны албан тушаалыг намдаа хандив өргөсөн, намын том дарга нарын тойрон хүрээлэгч болсон гэдэг шалгуураар хуваарилдаг, бусад намын харъяатуудыг төрийн албанаас халж "их цэвэрлэгээ" хийдэг жишиг тогтоод байгаа нь төрийн албаны залгамж чанарыг хангах, төрийн албыг чадварлаг мэргэжилтнүүд хаших зэрэг төрийн албаны зохион байгуулалтын зарчмуудад харшлаж байна.

Нөгөө талаас манай улсын төрийн төв ба орон нутгийн байгууллагуудад арван мянга гаруй албан хаагч ажилладаг бөгөөд тэдгээрийн дийлэнх нь төрийн албыг хуулийн дагуу хашиж үнэнч шудрагаар хөдөлмөрлөж байгаагийн дүнд төрийн алба дүн нуруугаараа хэвийн ажиллаж нийгмийн ардчилсан өөрчлөлтийн үйл хэргийг жолоодох үүргээ биелүүлж байна.

Манай оронд ардчилсан нийгмийн институтүүдийг хэлбэрийн хувьд байгуулсан боловч тэдгээрийг үүрэг зориулалтынх нь дагуу, хуулийн дагуу үр ашигтай ажиллуулахад улс төрийн зүтгэлтнүүд болон төрийн албан хаагчдын дотор албан тушаалаа урвуулан ашиглах, албан тушаалын наймаа хийх, хээл хахууль авах явдал хавтгайрсан нь гол саад болж байна. Эдгээр үзэгдэл бол улс орны эдийн засгийн өсөлтөд учирч байгаа гол саад тотгор юм. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахгүйгээр ядуурлыг "ялах" тухай яриа бол зөвхөн суртал нэвтрүүлэг юмуу сайхан мөрөөдөл болж үлдэнэ. Энэ хорт үзэгдлүүд одоогийнх шигээ цэцэглээд байвал Монгол орон ядуу дээрээ улам ядуу болж ядууралтай хийх дайнд авлигач, хахуульч, хүнд сурталтнууд ялдаг хэвээрээ байх болно.

Одоо хуурмаг, хэлбэрийн ардчиллыг жинхэнэ олон түмний оролцоотой, засаг төрд иргэдийн зүгээс тавих хяналттай, байнга ажилладаг амьд засаг болгон хувиргах зорилт бидэнд тулгараад байна. Олон түмэн нийгмийн зохион байгуулалт бүхэлдээ юмуу төр засгийн байгууллагуудын үйл ажиллагаа шударга биш байна гэж үзвэл, өөрөөр хэлбэл тэдний дургүйг

хүргэж байвал шударга ёс тогтоохын төлөө үйлдэлд шилждэг, тэмцдэг билээ. "Шударга бус байдлаас илүү бидний дургүйг хүргэдэг юм байхгүй. Бид тэсэх хэрэгтэй болдог бусад бүх нүгэл түүний дэргэд юу ч биш" гэсэн нэрт философич И.Кантын үг манай орны одоогийн бодот байдлыг л хэлээд байна.

Нийгмийн бодлого

Нийгмийн шударга биш байдал бол тухайн орон дахь эд баялаг болон орлогын үлэмж их шударга биш хуваарилалтын үр дүн гэж үздэг. Энэ бол чухал боловч зөвхөн нэг тал нь юм. Хүний эрхтэй холбогдуулан авч үзвэл шударга байдал бол зөвхөн дам хамгаалж болох бүх үндсэн эрхтэй холбоотой асуудал болж ирнэ.

Хувь хүний эрх чөлөөг дээдэлдэг ардчилсан нийгэмд бол иргэд шударга хөдөлмөр, авъяас билиг, зүтгэлээрээ их орлого олох, хөрөнгө мөнгөтэй болоход тавьдаг хориг саад байдаггүй. Тэд орлого, хөрөнгийн зэрэг татваруудыг хугацаанд нь төлж байх хуулиар тогтоосон үүрэгтэй. Их орлого, хөрөнгөтэй хүмүүсийн төлж байгаа татварууд нь улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд дорвитой хувь эзэлдэг бөгөөд тэгсэнээрээ тэд улс орондоо Үндсэн хуулиар тунхагласан хүний эрхүүдийг хангахад чиглэсэн төрийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж байдаг.

Ардчилал, зах зээлд шилжих явцад манай нийгэмд эд баялаг, орлогын ялгарал төдийгүй туйлшрал гараад байна. 2002-2003 онд Үндэсний Статистикийн Газраас (ҮСГ) хийсэн "Өрхийн орлого, зарлага, амжиргааны түвшний судлагааны үндсэн тайланд" "Жини коэффициентээр тэгш бус байдлыг хэмжихэд 0.33 байгаа бөгөөд тэгш бус байдал нь хот суурин газруудад хөдөөнөөс илүү байна. Хүн амын хамгийн чинээлэг 20 хувь нь хамгийн ядуу 20 хувиас 5.5 дахин их хэрэглээтэй байна" (2,9-10 дахь тал) гэсэн нь манай орон дахь тэгш биш байдлын үнэн дүр зургийг гаргахад хангалтгүй юм. Хүн амын тэнцүү бүлгүүдийг хэрэглээнийх нь хэмжээгээр харьцуулснаас хөрөнгө, орлогоор нь харьцуулах нь илүү бодтой үр дүн өгдөг бөгөөд дэлхийн аль ч улсын статистикт өргөн хэрэглэдэг аргачлал юм. ҮСГ энэ талаар ямар ч мэдээлэл гаргадаггүй.

Манай баян гэр бүл ядуу гэр бүлээс жишишгүй их хөрөнгө, орлоготой гэдгийг хүмүүс багцаагаар мэдэж байгаа ч энэ тухай судлагааны баримт

хэрэгтэй байна. 2004 оны 12 сард УИХ-ын хэд хэдэн гишүүн хөрөнгө, орлогынхоо тухай анх удаа хэвлэлд ярилцлага өгсөн байна. УИХ-ын гишүүн Батжаргалын Батбаяр жилдээ 100 саяаас дээш төгрөгийн орлоготой /"Өнөөдөр" 2004.12.15 №291/, гишүүн Даваажавын Ганхуяг "манай гэр бүлийн орлого сардаа нэг сая орчим төгрөг болдог... нэг жилийн ногдол ашиг 40000 ам доллар орчим" гэж ярьжээ. /"Өнөөдөр" 2004.12.09 № 286/ Энд тухайн өрхийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн талаар дурьдаагүй байна. Эндээс өрх болгон өөрийнхөө орлогыг дээрх хоёр гишүүний өрхийн орлоготой харьцуулаад хэд дахин их юмуу бага байгаагаа мэдэхэд амархан байна. Ерөөсөө хөрөнгө орлогын мэдүүлэгийг УИХ, ЗГ-ын гишүүд төдийгүй манай бүх өрх жил болгон өгч байх ёстой бөгөөд ингэснээр өрх бүр хөрөнгө орлогоо зөв мэдүүлж, оногдох татвараа төлдөг болохсон.

Манай орон зах зээлийн харилаанд шилжсэн өнгөрсөн арван тавхан жилд хүн амын өчүүхэн хэсэг нь баяжиж, бараг тал хувь тартагтаа тултал ядуурч, баян хоосны ялгаа төдийхөн биш бүр туйлшрал үүсчээ. Тэгвэл энэ нийгэм дэх төрийн нийгмийн бодлогын зорилго, зорилт юу байх вэ? Ядуу орны төр Үндсэн хуулиндаа заасан хүний эрхүүдийг эдлүүлэх нөхцөл бололцоогоор иргэдээ хангах үүргээ биелүүлэхэд хөрөнгө санхүүгийн гачигдлаас төрсөн их бэрхшээлүүдтэй учирдаг. Нөгөө талаас нийгмийн эрс өөрчлөлт шинэчлэлтийн үед манай оронд үүссэн ажилгүйдэл, ядуурал, их нүүдэл мэт нийгмийн олон хурц асуудал иргэдийн сурч боловсрох, эмчлүүлж сувилуулах мэтийн төрөөс үзүүлж байгаа нийгмийн үйлчилгээг адил тэгш хүртэх эрхийг хот хөдөөд харилцан адилгүй болгож байна. Нэг үгээр хэлбэл манай оронд хүний эрхийг хангахад туйлын сөргөөр нөлөөлж байгаа нийгмийн шинжтэй олон хүчин зүйл байгаагаас юуны өмнө улс орны эдийн засгийн ядуу буурай байдал онцгой нөлөөтэй байна. Үүний уршгаар ажилгүйдэл ядуурлын түвшин дорвитой буурахгүй байна. Засгийн газраас тогтоож байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, амжиргааны түвшний доод хэмжээ хүний хэвийн амьдралыг хангахад хүрэлцэхгүй байна. Мөн тэтгэврийн доод хэмжээ, тэтгэмжүүдийн хэмжээ ч чамлахаар бага байна.

Ядуу эдийн засаг, хомс төсөв бол төрийн нийгмийн хамгааллын бодлого арга хэмжээнүүдийг дорвитой хэрэгжүүлэх бололцоо олгохгүй нь ойлгомжтой. Тийм болохоор энэ бодлого ёстой хойд хормойгоороо урд хормойгоо нөхөх маягаар нэлээн удаан үргэлжлэх төлөвтэй.

Төрийн нийгмийн бодлого бол иргэдийнхээ хувийн болон эдийн засаг, нийгэм-соёлын эрхийг хангах, эдгээр эрхээ эдлэх аль болох адил тэнцүү нөхцөл бололцоогоор хангахад оршино. Зах зээлийн нөхцөлд төр социализмын үеийнх шиг хөдөлмөрийн чадвартай бүх хүнийг ажил эрхлүүлж цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг төвлөрүүлэн хуваарилдаг байх бололцоогүй, ийм үүрэггүй ч гэсэн нийгмийн тэгш биш байдлыг гааруулах биш бууруулах бодлого баримтлах нь дэлхийн жишиг болжээ. Тэр тусмаа хөдөлмөрийн насны хүн амын дотор орлого багын сацуу тэтгэвэр тэтгэмж авагч, халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын тоо өсөх хандлагатай, ядуурал нийгмийн гол бэрх асуудал болсон манай оронд төрийн зүгээс хүн амын эмзэг ядуу бүлгүүдэд зориулсан төсвийн болон бусад эх сурвалжийн (гадаад дотоодын хүмүүнлэгийн тусламж, буяны өргөл мэт) хөрөнгийг нэмэгдүүлэх явдал онцгой чухал ач холбогдолтой байна. Чингэхлээр төрийн нийгмийн бодлогод татварын бодлогоор дамжуулан орлогын дахин хуваарилалт хийх үүрэг байсаар байгаа төдийгүй ач холбогдол нь буураагүй байна гэж үзвэл зохилтой.

Гэтэл монголын улс төрчид нийгмийн бодлогын талаар үндэслэл тооцоо муутай, авцалдаагүй, хариуцлагагүй юм ярьж, суртал нэвтрүүлэг хийсээр байна. Тухайлбал одоо албан татваруудыг бууруулах, аж ахуй нэгжүүдийн орлогын татварыг 15% хүртэл буулгаж шатлалгүй болгох тухай ярьж байна. Энэ хэний сонирхолд үйлчилж байгаа нь ойлгомжтой. Хөгжингүй орнуудад орлогын татвар их өндөр байсан бөгөөд орлого нь төсвийн гол эх сурвалж болж байгаа дунд ангийн хувийн жин ихээхэн өссөн 1980-90-ээд оноос л татвар оногдуулах дээд хэмжээг бууруулж эхэлжээ. Манай оронд дунд анги татварын ачаа үүрдэг болтол татварын одоогийн хоёр шатлалтай тогтолцоог хадгалах нь улс төр, эдийн засаг, нийгмийн бодлогын ач холбогдолтой.

Одоо Эвслийн засгийн газар амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхийн бүх хүүхдэд сар бүр 3000 төгрөг олгож байхаар боллоо. Ингэж "хүүхдийн мөнгө" эргэж ирсэн нь сайн хэрэг. Дашрамд тэмдэглэхэд энэ шийдвэрийн ачаар манай улсын ядуу өрхийн яс тоо, ядуу хүмүүсийн яс тоог гаргаж иржээ. ҮСГ 1995, 1998, 2003 онд өрхийн амжиргааны түвшиний түүвэр судалгаа хийж, 1998, 2003 оны байдлаар ядуус нийт хүн амын 36 хувь болж байна гэсэн дүн гаргасан билээ. Хүүхдийн мөнгө олгох болсонтой

холбогдуулан НХХЯ-наас гаргаж байгаа мэдээгээр бол 266,7 мянган өрхийн 609,1 мянган хүүхэд тэтгэлэг авах нь ээ. ("Өнөөдөр" сонин 2005.6.9, №135) Энэ бол 2003 оны эцэст байсан бүх өрхийн (585 мянга) 45.6 хувь, нийт хүн амын 45.8 хувь болж байна.(Монгол улсын статистикийн эмхтгэл 2003, УБ 2004, 32,35 талд байгаа хүн ам ба өрхийн тооноос хувийг гаргав) Ядуус нийт хүн амын 36,1 хувь биш 45,8 хувийг эзэлж байна. 25-30 сая малаа хоёрхон долоо хоногт тоолчихдог 2.5 сая хүн амтай, 600000 өрхтэй манай оронд амьжиргааны түвшинг өрх бүрээр яс хэмжиж яс тоог нь гаргаж болохоор барахгүй энэ ажлыг хийх хөрөнгө хүч нь бэлэн байгаа юм. Тухайлбал ҮСГ, түүний харъяа нэгжүүд, УТЕА, түүний харъяа нэгжүүд, Нийгмийн халамжийн газар, түүний нэгжүүд орон нутгийн засаг захиргаатай хамтраад хийх ёстой ажил юм.

Ийнхүү манай оронд хүүхдийн мөнгөөр дамжуулан ядуу өрхүүдэд тэтгэлэг олгодог болж байна. Энэ бол УИХ-ын сонгуулийн үеэр "Эх орон-Ардчилал эвслийн" зүгээс өгсөн амлалт "төөрсөөр төрөлдөө" гэгчээр жинхэнэ эзэддээ очиж байна. Тэгэхдээ цаашид хүүхдийн мөнгийг өргөжүүлэн тараах тухай ярихгүй байх нь манай орны эдийн засаг, санхүүгийн боломж хийгээд ерөөс зах зээлийн нийгэмд иргэд өөрсдийнхөө төлөө, амьдрал ахуйнхаа төлөө хариуцлага хүлээдэг ардчилсан, чөлөөт эдийн засгийн зарчим, шаардлагад бүрэн нийцнэ. Ядуурлын эсрэг тэмцэх төрийн бодлогын ойрын үеийн зорилт нь хүүхдийн тэтгэлэг авдаг өрхийн тоог нэмэгдүүлэх биш харин бууруулхад чиглэх ёстой. Даанч хүүхдийн мөнгө манай иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээг сэдэрээж байгаа учраас ойрын жилүүдэд ялангуяа хүүхэд бүрт оногдох мөнгөний хэмжээ өсвөл хүүхдийн мөнгө авагчдын тоо нэмэгдэх нь илэрхий юм. Хүүхдийн мөнгө бол нийгмийн баялагийг шударга хуваарилах гол арга юм шиг М.Энхсайхан Л.Гүндалай нар яриад байгаа нь популист шинжтэй болохоос төдийлөн үнэмшилтэй биш юм. Ардчилсан нийгэмд төр бол төсвийн хэмжээ хязгаартай, манай оронд бол тарчиг хөрөнгийг боловсрол, эрүүл мэнд, төсвийн байгууллагуудад ажиллагсдын цалин, ахмад настны тэтгэвэр, тахир дутуу хүмүүс мэт эмзэг бүлгийнхний тэтгэлэгийг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээ, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулж байдаг. Тэр дотроо хүний капиталыг хөгжүүлэх зорилгоор боловсрол, эрүүл мэнд, мэргэжил олгох болон дахин мэргэжүүлэх сургалтад түлхүү хөрөнгө зарцуулж байдаг байна.

Резюме

Автор высказывает мнение о том, что несмотря на создание и функционирование институтов демократии таких как конституция и другие органические законы и соответствующие государственные учреждения, они работают и функционируют не всегда в соответствии с духом и буквами законов, что проявляется в расцвете коррупции, взяточничестве и бюрократизма в государственных органах, таких как Суды, Полиция, Таможенная служба и тд. Это является результатом отчасти политической незрелости политических партий Монголии, отчасти чрезмерной заинтересованности их деятелей в использовании высоких государственных постов для личной выгоды. Где практикуется последняя, там устанавливается власть узкопартийных группировок, там демократия превращается в нечто противоположное. Она искажается от установления власти узкопартийных бизнес-политических элитарных группировок до установления единоличной власти одного человека или одной семьи.

Если демократия в нашей стране приобретает черты власти узкопартийных элитарных группировок, если данные группировки способствуют коррупции и бюрократизации в государственных учреждениях, то о какой справедливой организации общественной жизни может идти речь? Если в государственных органах цветут коррупция и бюрократизм, если служащие государственных учреждений подвержены коррупции и взяточничеству, то трудно говорить о быстром экономическом росте, о преодолении бедности как об главной преграде экономического роста. К сожалению, данные явления широко распространены в нашей стране, и мы воюем против них главным образом голыми словами, а не делами.

Ашигласан эх суралж:

1. Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судлагааны үндсэн тайлан 2002-2003 он, УСГ, УБ 2004
2. "Өнөөдөр" сонин, 2004, 2005
3. Монгол улсын статистикийн эмхтгэл 2003, УБ 2004
4. Осадчая.И., 2005. Экономический рост, распределение доходов и политика государства. Ж."Наука и жизнь" №2, 24-29